Борнуур сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын эх сурвалжийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг, суурь үзүүлэлтийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардал 4,754,611.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 71,319.2 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 53,489.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтээс тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцох шаардлагатай байна

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардал 4,219,141.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 63,287.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 8,032.0 мянган төгрөгөөр буурсан байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 47,465.3 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Борнуур сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, төрийн сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Эмийн эргэлтийн сан, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан зэрэг 11 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем програмыг ашиглаж байна.

Орлогын талаар:

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагууд тусгай зориулалтын шилжүүлгээс 1,973,655.6 мянган төгрөгийн санхүүжилт, Эрүүл мэндийн даатгалаас 40,554.9 мянган төгрөгийн санхүүжилт, Орон нутгийн хөгжлийн сангийн 68,295.7 мянган төгрөгийн санхүүжилт, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 59,553.3 мянган төгрөг, 152,376.4 мянган төгрөг ЭЭС-ийн орлого, нийт 2,294,435.9 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг төвлөрүүлсэн байна.

Борнуур сумын ИТХ-ын Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 153,410.1 мянган төгрөг, татварын бус орлогыг 99,850.0 мянган төгрөг, нийт 253,260.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсөвт 2021 онд татварын орлого 195,155.8 мянган төгрөг, татварын бус орлого 189,183.2 мянган төгрөг, нийт 384,339.0 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг 131,078.9 мянган төгрөг буюу 151.8 хувиар биелүүлсэн байна. Орон нутгийн орлогын төлөвлөгөө өндөр хувиар биелэхэд малын тоо толгойн албан татвар 38,038.8 мянган төгрөгөөр шинээр нэмэгдсэн, үйл ажиллагааны орлогын албан татвар 32,855.8 мянган төгрөг, хөрөнгө борлуулсны албан татвар 10,726.6 мянган төгрөг, ойн төлбөр 12,951.9 мянган төгрөг, ус ашигласны төлбөр 7,530.8 мянган төгрөг, хүү торгуулийн орлого 45,034.6 мянган төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс давж орлого төвлөрсөн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 49,441.3 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 296,807.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор нийт 346,248.7 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба 117,592.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 249,166.0 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 24,885.4 мянган төгрөгийн, нийт 274,051.4 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 242,278.2 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна

Авлага, өглөгийн талаар:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд ажиллагсадтай холбогдсон авлага 4,261.4 мянган төгрөг, байгууллагаас авах авлага 93,164.3 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 297,572.6 мянган төгрөг, нийт 394,998.3 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн байна. Нийт авлагын 297,392.6 мянган төгрөг буюу 75.3 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Байгууллагад төлөх өглөг 32,873.7 мянган төгрөг, хувь хүмүүст төлөх өглөг 224.4 мянган төгрөг, нийт 33,098.1 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 477,298.8 мянган төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд 1,653.7 мянган төгрөг, нийт 478,952.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Авлага 394,998.3 мянган төгрөг, бараа материал 365,357.8 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 6,287,126.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
			Б
Мөнгөн хөрөнгө	378,529.7	478,952.5	100,422.8
Авлага	271,591.7	394,998.3	123,406.6
Урьдчилгаа	0	0	0.0
Бараа материал	328,394.0	365,357.8	36,963.8
Үндсэн хөрөнгө	6,371,503.7	6,287,126.6	-84,377.1
Нийт хөрөнгө	7,350,019.1	7,526,435.2	176,416.1
Өр төлбөр	25,622.1	33,098.1	7,476.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,324,397.1	7,493,337.1	168,940.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,350,019.1	7,526,435.2	176,416.1

Авлага дансны үлдэгдэл 394,998.3 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 123,406.6 мянган төгрөгөөр өссөн нь цэцэрлэгийн ажиллагсадтай холбогдсон авлага 1,723.6 мянган төгрөг, хүн эмнэлгийн байгууллагаас авах авлага 93,164.3 мянган төгрөгөөр, СХС-ийн авлага 28,816.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 365,357.8 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 36,963.8 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материал, бичиг хэрэг, хүнсний материалын үлдэгдэл өмнөх оноос өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,287,126.6 мянган төгрөг болж 84,377.1 мянган төгрөгөөр буурсан нь харъяа байгууллагууд тайлант онд 117,592.9 мянган төгрөгийн үнэ бүхий элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгө акталсан болон тайлант хугацааны элэгдлийн зардал 430,625.7 мянган төгрөг байгаа нь шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,493,337.1 мянган төгрөг болж 168,940.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сумын 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 3,420,982.0 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд болон хөрөнгийн зардалд зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Борнуур сумын ИТХ-ын Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 04 дүгээр тогтоолоор 2021 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 253,260.1 мянган төгрөгөөр, зарлагыг 3,340,873.9 мянган төгрөгөөр баталсан байна. Сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор төсвийн шилжих үлдэгдлээс 32,971.7 мянган төгрөгийг 2021 онд хийгдэх арга хэмжээг санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 3,373,845.6 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн 2021 оны төсвийн төслөөс 40,665.2 мянган төгрөгөөр бууруулан санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайланд 10 хөтөлбөр арга хэмжээнд зориулан 2,954,861.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 325,455.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 100,000.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 3,380,316.8 мянган төгрөг төсөвлөгдсөн. Энэ нь сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоос төлөвлөгөө нийт 6,471.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, батлагдсан төлөвлөгөөнөөс СӨБ 63,047.6 мянган төгрөгөөр дутуу, ЕБС 65,993.5 мянган төгрөгөөр илүү зөрүүтэй санхүүжигдсэн байна.

Нийт зардлын 2,097,016.5 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 568,667.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 64,770.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс, 199,951.8 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжих үлдэгдлээс, 253,260.1 мянган төгрөгийг сумын татварын болон татварын бус орлогоос, 90,179.3 мянган төгрөгийг сумын урьд оны шилжих үлдэгдлээс, 100,000.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 2,800,366.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 111,725.6 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 76,730.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 2,988,822.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 73,990.0 мянган төгрөгийг аймгийн төсөвт, 82,932.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,988,822.4 мянган төгрөг буюу 88.4 хувьтай хэрэгжсэн байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн нэгтгэсэн тайланд 463,378.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, бараа, ажил үйлчилгээний зардалд 323,457.1 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг, урамшуулалд 139,924.2 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 2,204.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Борнуур сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн тайланг түүвэрт хамруулж шалгасан. Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайланд 3,785.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 16,457.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 15,000.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж, ИТХ-ын санхүүгийн тайланд 3,000.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж, соёлын төвд 935.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, СХС-ийн санхүүгийн тайланд 192,215.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 54,615.1

мянган төгрөгийн 1 зөвлөмж, ОНХС-ийн санхүүгийн тайланд 1,200.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөн байна.

- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Дундманхайдай аудит ХХК тус сумын ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв гэсэн 3 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргаж, эмийн эргэлтийн сангийн тайланг түүвэрт хамруулан шалгасан байна. Аудитаар ЕБС-ийн санхүүгийн тайланд 454.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 126,471.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд 1,185.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, 31,208.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 46,232.3 мянган төгрөгийн 5 зөвлөмж, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 1,807.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 74,742.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж, ЭЭС-ийн санхүүгийн тайланд 104,975.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Борнуур сумын ИТХ-ын Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 04 дүгээр тогтоол, 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор тодотгон баталсан төсвийн төлөвлөгөөний үзүүлэлтүүд зөрүүтэй зөрчлийг ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тодруулах шаардлагатай байна.

Аж ахуй нэгж, байгууллагын татварын тодорхойлолтыг Татварын албанаас гаргуулан татварын авлага, өглөгийг тулгахад сумын ЗДТГ 78,784.3 мянган төгрөг, ИТХ 452.5 мянган төгрөг, Соёлын төв 49.2 мянган төгрөг, ЕБС 63.6 мянган төгрөг, Цэцэрлэг 121.1 мянган төгрөгөөр илүү, ЗДТГ 13,010.8 мянган төгрөг, Соёлын төв 2.6 мянган төгрөг, ЕБС 36.0 мянган төгрөг, Эмнэлэг 553.5 мянган төгрөгөөр тус тус дутуу, нийт 94,360.2 мянган төгрөгийн зөрүү тооцоолол татварын цахим санд үүссэн байна.

Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, Бороо гоулд ХХК-аас цагаан сараар ахмадуудад 4,162.5 мянган төгрөгөөр дархлаажуулалтын витаминь багц, 7,555.0 мянган төгрөгөөр ковидын хандив тусламж, 10,000.0 мянган төгрөгөөр соёлын төвийн тохижилт, 27,000.0 мянган төгрөгөөр ЗДТГ-т хогны автомашин, 27,000.0 мянган төгрөгөөр бохир соруулах автомашин, 40,000.0 мянган төгрөгөөр 4-р багийн хадлангийн талбайн хашаажуулалтад, 3,199.7 мянган төгрөгөөр “Өсөх нахиа” цэцэрлэгийн камержуулалт, 7,371.3 мянган төгрөгөөр машины гадна зогсоол, 7,689.0 мянган төгрөгөөр гадна хүүхдийн тоглоомын талбай, 75.0 мянган төгрөгөөр ЗДТГ-ын ажилтнуудад харилцаа хандлагын тухай сургалт, 4,960.0 мянган төгрөгөөр хичээлийн шинэ жилээр зорилтод бүлгийн 75 хүүхдэд бэлэг, 3,600.0 мянган төгрөгөөр үе үеийн төгсөгчдийн нөхөрсөг тэмцээнийг зохион байгуулж, 480,000.0 мянган төгрөгийг сумын спорт зал барихад, нийт 658,930.5 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авсан байна.

Мөн Тайшир өргөө ХХК-иас 40 тн чингэлэг, Гүн билэгт гоулд ХХК-иас 7,500.0 мянган төгрөгөөр явуулын чингэлэг авсан байна. Ажилтнууд аж ахуйн аргаар 4 автомашины граж барьж орлогод авсан байна.

Эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр үндсэн хөрөнгө, автомашин бусад хөрөнгийг улс орон нутгийн орлогод хураагдсан хөрөнгийг хүлээж авах, Бороо гоулд ХХК-тай байгуулсан гэрээний дагуу томоохон хөрөнгө бусад ажлыг хүлээн авах комисст сумын өмч хамгаалах байнгын зөвлөл, дотоод хяналтын ажлын хэсгийн хяналт дор хэрэгжүүлж, тэмдэглэл хөтөлж байх тусгай журам мөрдөх шаардлагатай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Борнуур сумын Засаг даргын Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс хугацаандаа оруулсан 101 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 52 мэдээлэл байна. Хэрэгжилт 83.0 хувьтай байна. Шилэн дансны мэдээлэлд төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг бичиж мэдээлэх, дараа жилийн төсвийн төсөл болон ТТЗ-ийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтийг мэдээлээгүй зэрэг зөрчил гарсан байна

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/217 дугаар албан бичгээр ирүүлсэн ба орон нутгийн орлогыг нэр төрлөөр биелүүлэх шилэн дансны мэдээллийг үнэн зөв байршуулах зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад газар эзэмших, ашиглах эрх шилжилтийн бүртгэлийн судалгааг газрын даамлаас авч татварыг бүрэн авсан эсэхийг тулган шалгах, аймгийн ИТХ-аар шийдвэрлэгдсэн хөрөнгийг худалдан борлуулж, орлогыг төсөвт бүрэн оруулах асуудалд дараагийн аудитаар анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Борнуур сумын Засаг даргын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 170,567.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 36,521.0 мянган төгрөгийн залруулга, 2,672.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 94,360.2 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 37,014.1 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгөв.

Санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан Борнуур сумын ИТХ-ын санхүүгийн тайланд 7,119.8 мянган төгрөгийн 1 алдаанд залруулга, 3,000.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж, Соёлын төвийн санхүүгийн тайланд 14,647.9 мянган төгрөгийн 1 алдаанд залруулга, 935.6 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, Сум хөгжүүлэх сангийн 192,215.3 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 54,615.1 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж, ОНХС-ийн 1,200.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж, эргэлтийн эмийн сангийн 104,975.0 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж хүргүүлж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан байна.

4.1 Залруулсан алдаа

Борнуур сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлант хугацааны үр дүнг 11.268.6 мянган төгрөгөөр дутуу, ОНЕО-д туслах үйл ажиллагааны орлогыг 10.931.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнаж, үнэ төлбөргүй хүлээж авсан орлогыг 14.320.8 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй, нийт 36,521.0 мянган төгрөгийн алдаатай тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Сумын ИТХ-ын төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн 872.5 мянган төгрөгөөр тохируулаагүй, зөрүүтэй тайлагнасан байна. Зөвшөөрөл нь гараагүй байхад 6.247.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авсан, нийт 7,119.8 мянган төгрөгийн алдаа байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Сумын соёлын төв нь төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардал болон, санхүүжүүлэх эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн 14.647.9 мянган төгрөгөөр тохируулаагүй, зөрүүтэй тайлагнасан алдаа байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Борнуур сумын нэгтгэлд хамрагдагч байгууллагууд хүн эмнэлэгийн 709.1 мянган төгрөг, цэцэрлэгийн 863.7 мянган төгрөг, соёлын байгууллагын 253.1 мянган төгрөг, ИТХ-ын 846.1 мянган төгрөг, нийгмийн даатгалын байгууллагад нийт илүү төлсөн 2.672.0 мянган төгрөгийг авлагаар бүртгэж тайлагнаагүй, төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “тасалбар болголт”, “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.4-д “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

Сумын Засаг даргын 2021 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн Б/165 тоот захирамжаар Соёлын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Нандинцэцэгт бүжгийн багшийн ажлыг хавсруулан гүйцэтгүүлж, 40 хувийн нэмэгдэл цалинд 935.6 мянган төгрөг олгосон зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Хөдөлмөрийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Хуулийн этгээдэд эд хөрөнгө захиран зарцуулах эрх мэдэл хэрэгжүүлэх ажил, албан тушаалд ажилладаг ажилтан адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг өмчийн бусад төрөл, хэлбэрийн өмчлөгчтэй эрхэлж байгаа ажил, албан тушаалтайгаа ижил, эсхүл удирдах, хяналт тавих шинжтэй ажил, албан тушаалд ажиллахаар зэрэгцсэн гэрээ буюу контракт байгуулахыг хориглоно” 28.2-д “Энэ хуулийн 28.1 нь хавсран ажиллахад нэгэн адил хамаарна.”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

4.3 Албан шаардлага

Төсөвт байгууллагуудын татварын өр авлагын тодорхойлолтыг etax.mta.mn системээр гаргахад төсвийн нийт 6 байгууллагад 14,889.6 мянган төгрөг дутуу, 79,470.6 мянган төгрөг илүү үлдэгдэлтэй, нийт 94.360.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь ТТЗ-ийн нэгтгэсэн тайлангийн өр, авлагын үлдэгдэлтэй тохирохгүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “тасалбар болголт”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.5-д “төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг тооцоо хийж, баталгаажуулсан байдал болон зээлийн хугацаа хэтрэлтийг зээлдэгч бүрээр тулгахад 192,215.3 мянган төгрөгийн хугацаа хэтрэлттэй зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7-д “авлага, өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Борнуур сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 3 зөрчилд зөвлөмж, түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайлангийн 8 зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орон нутгийн орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр биелсэн эсэхийг шалгахад суутган-2 татвар 7,226.3 мянган төгрөгөөр буюу 55.6 хувиар, бууны татвар 278.0 мянган төгрөг буюу 21.6 хувиар, ТТАМ ашигласны төлбөр 27,600.0 мянган төгрөг буюу 64.2 хувиар, газрын төлбөр 1,009.8 мянган төгрөг буюу 5.3 хувиар, түрээсийн орлого 900.0 мянган төгрөг буюу 60,0 хувиар, нийт 5 нэр төрлийн орлого 37,014.1 мянган төгрөгөөр тасарсан зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 54 дүгээр зүйлийн 54.5.1-д “тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлэх

2. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлөөр үндсэн хөрөнгө, автомашин бусад хөрөнгийг улс орон нутгийн орлогод хүлээж авах, Бороо гоулд ХХК-тай байгуулсан гэрээний дагуу томоохон хөрөнгө бусад ажлыг хүлээн авах комисст сумын өмч хамгаалах байнгын зөвлөл, дотоод хяналтын ажлын хэсгийн хяналтан дор хэрэгжүүлээгүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Өмч хамгаалах байнгын зөвлөл, дотоод хяналтын ажлын хэсгийн хяналт дор хэрэгжүүлж, тэмдэглэл хөтөлж байх

3. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

ТТЗ-ийн Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 155 мэдээллээс хугацаандаа оруулсан 101 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 52 мэдээлэл байна. Хэрэгжилт 83.0 хувьтай байна. Шилэн дансны мэдээлэлд төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг бичиж мэдээлэх, дараа жилийн төсвийн төсөл болон ТЭЗ-ийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтийг мэдээлээгүй зэрэг зөрчил байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх зарчмуудыг хангуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулах

4. Тайлан, мэдээ гаргалттай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Сум хөгжүүлэх санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг аймгийн ХХААГ-аас ирүүлсэн сангийн авлагын дүнтэй тулгахад 54,615.1 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сум хөгжүүлэх сангийн авлагын дүнг ХХААГ-ийн тайлангаас зөрүүтэй мэдээлж буй зөрчлийг арилгаж, зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдлийг зөрүүгүй үнэн зөв тайлагнаж байх.

5. Худалдан авалттай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхгүйгээр ГХЗУСАЗСЗ-ийн тогтоол шийдвэргүйгээр, иргэнтэй гэрээ байгуулж 3,000.0 мянган төгрөгийн зарын самбар худалдан авсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.4-д “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж,

хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж байх.

6. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт:

ОНХС-ийн эхний үлдэгдэл 201,151.8 мянган төгрөг байхад сумын ИТХ-н тогтоолоор 199,951.8 мянган төгрөг гэж 1,200.0 мянган төгрөгөөр зөрүүтэй баталсан зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ОНХС-ийн үлдэгдлийг ИТХ-ын тогтоолд үнэн зөв батлах

7. Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой асуудал

7.1. Илрүүлэлт:

Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг 2 оноор зэрэгцүүлж тайлагнаагүй зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” заалт, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” журмын 2.1.8-д “Төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нь өмнөх үеийн болон бусад төсвийн байгууллагын санхүүгийн тайлантай зэрэгцүүлэхүйц” байх зарчим болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эргэлтийн эмийн сангийн тайлангийн мэдээллүүдийг зэрэгцүүлсэн байдлаар тайлагнах

8. Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой асуудал

8.1. Илрүүлэлт:

Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 5,781.1 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.5-д “хэмжигдэхүйц байх”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дугаар тушаалын 7.1 “... элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж, шийдвэрлүүлнэ.” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн үнэ цэнэ, эдийн засгийн үр өгөөж хүртэж буй эсэхийг үнэлэн, үнэлгээнд үндэслэн актлах хөрөнгө болон дахин үнэлүүлэх шаардлагатай хөрөнгийн жагсаалтыг сумын ИТХ, өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлж байх

9. Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой асуудал

9.1. Илрүүлэлт:

Эргэлтийн эмийн сангийн тайлант хугацааны борлуулалтын орлогыг цахим баримттай тулган шалгахад 99,193.9 мянган төгрөгийн борлуулалтын орлогыг анхан шатны албан ёсны баримтаар баталгаажуулаагүй зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эргэлтийн эмийн сангийн борлуулалтын орлогыг албан ёсны анхан шатны цахим баримтаар баталгаажуулж байх

10. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

10.1. Илрүүлэлт:

Сумын ЭЭС-ийн Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс хугацаандаа оруулсан 137 мэдээлэл, хугацаа хоцроосон 8 мэдээлэл, байршуулаагүй 2 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх зарчмуудыг хангуулах”, Засгийн газрын 2016 оны 29-р тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй бөгөөд санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Нэгтгэгдсэн байгууллагууд	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Борнуур Засаг дарга	6	170,567.3	1	36,521.0	1	2,672.0	1	94,360.2	3	37,014.1
2	Борнуур ЗДТГ	5	394,807.1	1	359,564.1	1	3,785.4	1	16,457.6	2	15,000.0
3	Борнуур ИТХ	2	10,119.8	1	7,119.8		-		-	1	3,000.0
4	Борнуур Соёлын төв	2	15,583.5	1	14,647.9	1	935.6		-		-
5	Борнуур СХСан	2	246,830.3		-		-	1	192,215.3	1	54,615.1
6	Борнуур ОНХСан	1	1,200.0		-		-		-	1	1,200.0
7	Борнуур БНСБСан	0	0.0		-		-		-		-
8	Борнуур ЕБС	9	156,741.6	5	29,816.6	1	454.0	0	-	3	126,471.0
9	Борнуур СӨБ	11	79,525.7	2	899.7	1	1,185.7	3	31,208.0	5	46,232.3
10	Борнуур ЭМТөв	5	76,550.4		-	1	1,807.6	1	-	3	74,742.8
11	Угтаалцайдам ЭЭСан	4	104,975.0		-		-		-	4	104,975.0
	Нийт дүн	47	1,256,900.8	11	448,569.1	6	10,840.4	7	334,241.0	23	463,250.3